



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ АГААРЫН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ХЭЛТСИЙН 2019 ОНЫ III УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН
АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2019.10.07

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

ЗТХЯ-ны АТБХЗХ-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

АТБХЗХ-ийн 2019 оны III улирлын үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт, СЗХ-наас гарсан шийдвэрийн хэрэгжилт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 10 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **82,1%**-тай байна. /Хүснэгт 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. АТБХЗХ-ийн 2019 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс				Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
54	22	14	6	2	10	76.4%

ЗТХЯ-ны АТБХЗХ нь 2019 онд 54 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт 54 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 22 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 14 арга хэмжээ, 30%-ийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, 0%-ийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа болоогүй 7 арга хэмжээ, хэрэгжих боломжгүй, шаардлагагүй болсон 3 арга хэмжээ буюу хэрэгжилт дунджаар 80,2%-тай байна. Бүрэн хэрэгжээгүй 22 арга хэмжээний 10 нь хэрэгжүүлэх хугацаа хэтэрсэн арга хэмжээ байна.

Хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжих хугацаа дууссан арга хэмжээ:

1/ 1.1 Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, батлуулах. /7-9 сар Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна/

Биелэлт: Иргэний нисэхийн тухай хуулийн төсөлд 2019.03.15-ны өдрийн 01/1173 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авсан. Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авах, хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулахаар ХЗДХЯ /2019.05.08-ны 01/2367 тоот албан бичиг/, Сангийн яаманд /2019.05.08-өдрийн 01/2367 тоот албан бичиг/-ээр тус тус хүргүүлж хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авсан.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, төслийг сайжруулан дахин хэлэлцүүлэхээр тогтсон. Сайдын зөвлөлийн гишүүдийн санал, чиглэл болон ХЗДХЯ, Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, саналыг нэгдсэн байдлаар тусган хуулийн төсөлд редакцийн чанартай өөрчлөлт хийсэн. Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний дараа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ. 30%

2/ 1.2 “Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийн төслийг боловсруулан батлуулах (орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ, орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ) /4-9 сар Үзэл баримтлалын төслийг батлуулж, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна/

Биелэлт: Хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан, батлуулахаар ажиллаж байна.

ЗТХЯ-ны 2019.09.12-ны өдрийн 09/4825 тоотоор ИНЕГ-ыг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу холбогдох хавсралтуудыг дахин боловсруулж ирүүлэхийг мэдэгдсэн. 0%

3/ 1.3 Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл) /7-12 сар Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна/

Биелэлт Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар Сангийн сайдад хүргүүлэх шатанд байна. 30%

4/ 1.5 Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны санхүүжилт, бүтэц зохион байгуулалтын санал боловсруулах, шийдвэрлүүлэх /1-3 сар Сайдын тушаалаар шийдвэрлүүлсэн байна/

Биелэлт: НТОЗШША-ны 2019 оны төсөв, санхүүжилтийг Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2018.12.31-ний өдрийн 305/313 дугаар хамтарсан тушаалаар батлан шийдвэрлэсэн.

НТОЗШША-наас 2019.01.04-ний 03/19 болон 02/19 тоот албан бичгээр санхүүжилт, бүтэц зохион байгуулалтын талаар ирүүлсэн хүсэлтийн дагуу 2019.01.14-ний өдөр НТОЗШША, ИНЕГ-ын удирдлагуудтай хийсэн уулзалтаар дээрх тушаалыг НТОЗШША-ны даргад өгч, санхүүжилтийн саналаа ИНЕГ-т хүргүүлэх, ИНЕГ-т санхүүжилтийн хуваарийг хийх чиглэл өгсөн.

НТОЗШША-аас 2019 оны төсвийн санал ИНЕГ-т 2019.01.10-ны 09/19, 10/19 тоот албан бичгээр хүргүүлж, ИНЕГ-аас 2019.01.29-ний 05/369 тоот албан бичгээр НТОЗШША-ны 10 орон тооны цалингийн зардал, 2019 оны төсвийн хуваарилалтыг хийж хүргүүлсэн.

Албаны бүтэц зохион байгуулалтыг Зам, тээврийн хөгжлийн сайдын “Бүтэц зохион байгуулалт, орон тоо, дүрмийг шинэчлэн батлах тухай” 2018 оны 171 дүгээр тушаалаар баталсны дагуу 10 орон тоотой байхаар 2019 оны төсвийг ИНЕГ-ын үйлдвэрлэлийн албадын төсөвт тусган Зам, тээврийн сайд, Сангийн сайдын 305/313 дугаар тушаалаар баталсны дагуу хэрэгжүүлж байна. Мөн НТОЗШША-ны гадаад сургалтын зардлыг ИНЕГ-ын Даргын зөвлөлийн 2019.01.31-ний өдрийн хурлаар хэлэлцэн 3.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас орон тоог шийдвэрлэх, цалингийн санг нэмэгдүүлэх талаар ирүүлсэн хүсэлтийг судлан аюулгүй ажиллагааны байцаагчийн жишгээр цалингийн түвшинг тогтоох, орон тоог шийдвэрлэх чиглэл өгч ИНЕГ-т, албаны санхүүжилт, орон тоо, цалингийн асуудлыг хамтран Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх чиглэл ИНЕГ болон НТОЗШША-д өгсөн, бэлтгэх шатанд байна. /2019.08.23-ны 09/4509; 09/4510 тоот, 2019.09./ 70%

5/ 1.6 Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх /4-6 сар Нислэг техникийн зөрчлийн шалтгаан, нөхцөлд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид бүх шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулан Сайдын зөвлөлд танилцуулсан байна/

Биелэлт: Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг гаргаж ирүүлэх чиглэл өгсний дагуу тус хэлтэст ирүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж, зөвлөмжийн хэрэгжилт удаашралтай байгаатай холбогдуулан ИНЕГ, “МИАТ” ТӨХК-д хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг НТОЗШША-д хүргүүлэх, НТОЗШША-д Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх чиглэл тус тус өгсөн. /2019.07.04-ний 03/3663 тоот албан бичиг/ Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас 2019.09.17-ны өдрийн 94/19 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг тодруулах, дүгнэх шатанд байна. 30%

6/ 2.11 Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх Зөвлөл, Агаарын тээврийг хялбаршуулах Зөвлөл, Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах /1-12 сар Зөвлөлүүдийн хурлыг жилд 2 удаа зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад дэмжлэг үзүүлнэ/

Биелэлт: Агаарын тээврийг хялбаршуулах Зөвлөл, Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлын алба хуралдаж, зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, шийдвэрийн төслийг боловсруулан ирүүлсэн. Сайдаас хурлын товьыг авахаар хүлээж байна.

Агаарын хөлөг шувуу мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлын албыг яаралтай хуралдуулж, зөвлөлийн хурлыг хуралдуулахаар холбогдох материалыг ирүүлэх чиглэлийг ИНЕГ-т удаа дараа өгсөн. 0%

7/ 3.4 Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Канад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангах /7-9 сар Хэлэлцээр байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна/

Биелэлт: “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Канад Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн үзэглэсэн төслийн эх бичвэрт Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны Чикагогийн конвенцийн дагуу хоёр улсын хооронд агаарын харилцаа тогтоох, томилогдсон агаарын тээвэрлэгчид тохиролцсон үйлчилгээ үзүүлэх эрх олгох, нислэг гүйцэтгэхтэй холбоотой нийтлэг зохицуулалтыг тохирсон байх бөгөөд уг Хэлэлцээрийн Хавсралтад зөвхөн аяллын дугаар хамтран ашиглах зарчмаар нислэг гүйцэтгэхээр маршрутын хуваарийг тогтоосон нь эрх зүйн хувьд зөрчилтэй болсон тул асуудлыг Канадын талаас тодруулах чиглэл ИНЕГ-т хүргүүлсэн. /2019.07.22-ны 09/2935 тоот албан бичгээр/ Асуудлыг Канадын талаас тодруулсан бөгөөд 2019 оны 12 дугаар сард зохион байгуулах Агаарын харилцааны хэлэлцээний бага хурлын үеэр төслийг дахин хэлэлцэхээр тогтсон талаар ИНЕГ-аас асуудлыг тодруулж ирүүлсэн. /2019.09.04-ний 01/2935 тоот албан бичгээр/

Үзэглэсэн төслийн зөрүүтэй байдлыг тодруулах, дахин хэлэлцэх болсон тул энэ онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээргүй болоод байна. 30%

8/ 3.5 Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Испанийн Вант Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангах /9-10 сар Хэлэлцээр байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна/

Биелэлт: "Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Испанийн Вант Улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээр"-ийн үзэглэсэн төсөлд холбогдох засварыг оруулж, Испанийн талтай тохирох чиглэл ИНЕГ-т хүргүүлсэн. /2019.07.22-ны 09/2935 тоот албан бичгээр/ Испанид 2019 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр болсон парламентийн сонгуулиас хойш Засгийн газрыг эмхлэн байгуулах ажил удаашралтай байгаатай холбоотой Агаарын харилцааны асуудлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан. ИНЕГ-аас асуудлыг тодруулж Испанийн талаас Агаарын харилцааны хэлэлцээрийн үзэглэсэн төсөлд засвар хийх асуудлыг 2019 оны 12 дугаар сард зохион байгуулах Агаарын харилцааны хэлэлцээний бага хурлын үеэр дахин хэлэлцэхээр тогтсон. /2019.09.04-ний 01/2935 тоот албан бичгээр ИНЕГ-аас ирүүлсэн/

"Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Испанийн Вант Улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээр"-ийн үзэглэсэн төслийн эх бичвэрт ишлэл хийсэн зүйл, заалтын дугаарлалт зөрсөн бичвэрийн алдааг засах, засвар хийх шаардлагатай тул Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэлгүй хойшлуулсан, энэ онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээргүй болсон. 30%

9/ 4.1 Хөшигийн хөндий дэх Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулах /7-9 сар Нисэх буудлыг ашиглалтад оруулсан байна./

Биелэлт: "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төслийн концессын гэрээг 2019.07.05-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээ 2019.09.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон. Концессын гэрээнд заасны дагуу Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг концессын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 сарын дараа буюу 2020 оны 7 сарын 1-ний өдрөөс өмнө ашиглалтад оруулна. Нисэх буудлыг ашиглалтад оруулахад шаардлагатай Зам, тээврийн хөгжийн яамнаас хийгдэх ажлууд бүрэн хийгдсэн. 70%

10/ 4.2 "Чингис хаан" ОУНБ-ыг шинэ нисэх буудалд нүүлгэн шилжүүлэх /7-9 сар Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна/

Биелэлт: Буянт-Ухаа дахь "Чингис хаан" ОУНБ-ын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ИНЕГ-ын даргын 2019 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/344 тоот тушаалаар шинэчлэн байгуулсан.

Ажлын хэсгээс "Нүүлгэн шилжүүлэлтийн нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Тус ажлын хэсэгт АТБХЗХ-ийн дарга болон ахлах мэргэжилтэн нар оролцон ажиллаж байна. "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө"-г Зам, тээврийн хөгжлийн сайдаар батлуулан Иргэний нисэхийн ерөнхий газар /2019.08.16-ны 09/4312 тоот/, "Нью Улаанбаатар интернэшнл эйрпорт" ХХК-д /2019.08.20-ны 09/4423 тоот/ тус тус хүргүүлсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг 2020.07.01-ний өдрийг хүртэл хэрэгжүүлэхээр тусгасан болно. 70%

11/ 4.3 Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орохтой холбогдуулан "Буянт-Ухаа" нисэх буудлыг цаашид иргэний нисэхийн чиглэлээр ашиглах асуудлыг шийдвэрлүүлнэ. /1-3 сар Холбогдох шийдвэрийг гаргуулсан байна/

Биелэлт: Буянт-Ухаа дахь одоогийн "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын цаашдын зориулалт ашиглалтын талаар "Буянт-Ухаа нисэх буудлын талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2019.07.29-ний өдрийн 01/4076 тоот албан бичгээр ЗГХЭГ-

т дахин хүргүүлсэн. ЗГХЭГ-аас тогтоолын төслийг дахин боловсруулж, яамдаас дахин санал авч ирүүлэх чиглэл өгч буцаасны дагуу яамдаас санал авах шатанд байна. /2019.09.18-ны 01/4972 тоот/

Буянт-Ухаа дахь одоогийн "Чингис хаан" олон улсын нисэх буудлын цаашдын ашиглалтын талаарх тооцоо судалгааг нарийвчлан хийх, сайжруулах чиглэл ИНЕГ-т өгсөн. /2019.09.25-ны 06/5074 тоот/ 70%

12/ 4.8 Өмнөговь аймгийн нисэх буудлыг 4D ангиллын олон улсын нөөц нисэх буудал болгох бэлтгэл ажлыг хангах /4-6 сар ТЭЗҮ, Зураг төслийг батлуулсан байна/

Биелэлт: Өмнөговь аймгийн "Гурвансайхан" нисэх буудлын Зорчигч үйлчилгээний барилга, байгууламжийн зураг, төсвийг боловсруулах ажлын явц 80%-тай байна.

Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний хугацаа 2018.04.21-ний өдөр дууссан байгаа тул гэрээт ажлыг эрчимжүүлэх талаар чиглэлийг ИНЕГ-т өгсөн. 70%

13/ 4.9 Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах ЗС хүчин чадалтай болгох төслийг удирдлага, зохион байгуулалтаар хангах /7-12 сар Барилгын ажлын гүйцэтгэл 20%/

Биелэлт: Төрийн нарийн бичгийн даргын 2019.05.02-ны өдрийн 151 дүгээр тушаалаар "Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулсан. Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг 2019.08.05-нд зарласан. 30%

14/ 4.13 "Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга"-ыг ашиглалтанд оруулах /4-9 сар Оффисын барилгыг ашиглалтад оруулсан байна/

Биелэлт: "Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилга"-ын ажлыг "Үүрэг трейд" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд нийт гүйцэтгэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 91%-тай, одоогоор барилгын ажил зогссон байна.

Уг гэрээт ажлын явцын талаар 2019.06.03-ны өдөр Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулсан. СЗХ-ын шийдвэрийг 2019.06.21-ний өдөр ИНЕГ-т хүргүүлсэн. Барилгыг 2019 оны 10 сард багтаан ашиглалтад оруулна. 70%

15/ 4.14 Шинэ нисэх буудал ашиглалтад орохтой холбогдуулан Улсын тусгай хэрэгцээний газарт аж, ахуйн нэгж байгууллагад газар ашиглуулах асуудлыг шийдвэрлүүлэх. /Скайкатеринг ХХК, .../ /4-9 сар Аж ахуйн нэгж байгууллагад газар ашиглуулах асуудлыг шийдвэрлүүлсэн байна/

Биелэлт: Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор баталсан "Газрыг тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ заагийг тогтоох, ашиглах журам"-д заасны дагуу тусгай хэрэгцээний газрын эзэмшил, ашиглалттай холбоотой асуудлыг шийдвэрлүүлж, Зам, тээврийн хөгжлийн яам, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Төв аймгийн Засаг даргатай хамтран 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Улсын тусгай хэрэгцээний газрыг ашиглах 155 дугаар гэрээг байгуулсан. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлуулснаар Зам, тээврийн хөгжлийн яаманд нисэх буудлын зориулалтаар 2400 га газрын гэрчилгээг 2019.09.05-ны өдөр олгосон. Аж ахуйн нэгж байгууллагуудад газар ашиглуулах асуудлыг нэгтгэн шийдвэрлэх шатанд байна.

"Скайкатеринг" ХХК, Цагдаагийн байгууллага, "Монгол шуудан" ХХК-д газар олгуулах талаар ИНЕГ-т чиглэл өгч, шийдвэрлэсэн. "Скайкатеринг" ХХК нь 0,7 га газарт барилгын ажлаа эхлүүлсэн. 2019.12.15-ны өдрийн дотор Улсын комисст хүлээлгэн өгнө. 70%

2.2. МУ-ын ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс	Биелэлтийн хувь
------------	--------	-----------------

	100%	70%	40%	0%	Үнэлэх боломжгүй	
26	11	6	3	1	5	80,0%

Үнэлэх боломжгүй арга хэмжээ:

1/ 2.114.10. Ховд аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох /Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь 2017-2020/

Биелэлт: Ховд нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга, байгууламжийг өргөтгөх зургийн эскизийг ИНЕГ-ын даргаар 2019.03.15-ны өдөр батлуулсан. Зорчигч үйлчилгээний барилгын зураг төсвийг 2019.05.15-ны өдөр хүлээн авахаар “Алтайн газрын хүч” ХХК-тай гэрээг шинэчлэн байгуулсан. Зураг төсөв боловсруулах ажил 70%-тай.

Нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, аэродромыг 4С болгох ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байна. 2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. /үнэлэх боломжгүй/

2/ 2.114.11. Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох /Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь 2017-2020/

Биелэлт: ЗТХС, Сангийн сайдын хамтарсан 2018.12.31-ний өдрийн 305/313 дугаар тушаалаар Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох ажилд ИНЕГ-ын 2019 оны өөрийн орлогоос 1 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр баталсан.

Нисэх буудлын барилгын өргөтгөлийн ажлын зургийн даалгаврыг боловсруулж байна. “Аэродромыг 4С болгох ажлын зураг төслийн техникийн даалгавар”-ыг батлуулсан. Зураг төслийг боловсруулж байна.

Санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр бүхий л боломжит нөхцлийг эрэлхийлэн ажиллаж байна. /үнэлэх боломжгүй/

3/ 2.114.15. Чингис Хаан ОУНБ-ын үйл ажиллагааг шинэ нисэх буудалд шилжүүлэх, шинэ нисэх буудлын үйл ажиллагааг тогтворжуулах /Олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг тогтворжуулах 2017-2018/

Биелэлт: Шинэ нисэх буудалд үйл ажиллагаа явуулах 20 байгууллагын нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг нэгтгэн баталгаажуулж, ИНЕГ-ын тэргүүн дэд даргаар батлуулсан.

Нисэх буудлыг нүүлгэн шилжүүлэх нэгдсэн төлөвлөгөөнд 4 бүлэг 159 зүйл ажил багтсан. Үүнээс нисэх буудалд үйл ажиллагаа явуулах байгууллагуудтай гэрээ байгуулах, зай талбай, өрөө тасалгааны хуваарилалтыг баталгаажуулах, үйл ажиллагаа эхлэхэд шаардлагатай худалдан авалт хийх зэрэг тусгай зориулалт оператор компанитай шууд хамааралтай 130 ажил буюу нэгдсэн төлөвлөгөөний 86%-ийг эзэлж байна.

Нисэх буудлын оператор компани байгуулагдах хугацаа удаа дараа хойшилж байгаатай холбогдон тус төлөвлөгөөний биелэлт удаашралтай байна. Буянт-Ухаа дахь “Чингис хаан” ОУНБ-ын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ИНЕГ-ын даргын 2019 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/344 тоот тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгээс “Нүүлгэн шилжүүлэлтийн нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг концессын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 сарын дараа ашиглалтад оруулахаар хэлэлцээ хийгдсэн. /үнэлэх боломжгүй/

4/ 6.2.1.1. Өлгий хотын Нисэх буудлын хатуу хучилттай зурвасыг өргөтгөж, хүнд даацын том онгоц хүлээж авах боломжийг бүрдүүлнэ /Зураг төсвийг бэлэн болгох, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх 2017/

Биелэлт: Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна.

Баян-Өлгий аймгийн Өлгий хотын нисэх буудлыг тавдугаар түвшний техникийн хангамжид нийцүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх тухай Бүгд Найрамдах Казахстан Улсаас 2017.06.16-ны өдрийн 30/463 тоот ноот бичиг ирүүлсэн. Үүний дагуу тус нисэх буудалд газрын системд тулгуурласан нарийвчлалыг өсгөх систем /GBAS/-ийг суурилуулах, түүнд тулгуурласан нислэгийн журмыг боловсруулах, ойртолтын налуу заагч систем /PAPI/-ийг зурвасын гэрлийн системийн хамт суурилуулахад хамтан ажиллах саналаа ЗТХ-ийн сайдын 2017.11.07-ны өдрийн 01/4864 тоот албан бичгээр БНКУлсаас Монгол Улсад суугаа элчин сайдад хүргүүлсэн. /үнэлэх боломжгүй/

5/ 6.19.3.3. Олон улсын нисэх буудлын барилгыг өргөтгөх /Ажлыг бүрэн дуусгаж, улсын комисс хүлээн авах 2017-2018/

Биелэлт: Ховд нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга, байгууламжийг өргөтгөх зургийн эскизийг ИНЕГ-ын даргаар 2019.03.15-ны өдөр батлуулсан. Зорчигч үйлчилгээний барилгын зураг төсвийг 2019.05.15-ны өдөр хүлээн авахаар “Алтайн газрын хүч” ХХК-тай гэрээг шинэчлэн байгуулсан. Зураг төсөв боловсруулах ажил 70%-тай.

Нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, аэродромыг 4С болгох ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байна. 2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. /үнэлэх боломжгүй/

Хэрэгжилт хангалтгүй байгаа арга хэмжээ:

6/ 2.114.12 Өмнөговь аймаг дахь нисэх буудлыг 4D ангиллын, олон улсын нөөц нисэх буудал болгох /Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь 2017-2020/

Биелэлт: Өмнөговь аймаг дахь нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэл 80%-тай байна.

Нисэх буудлыг 4D ангиллын, олон улсын нөөц нисэх буудал болгох Зам, тээврийн хөгжлийн сайдын 2 дугаар сарын 01-ний өдрийн 35 дугаар тушаалаар батлуулсан “ИНЕГ-ын 2011, 2013, 2015, 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн зарцуулагдаагүй үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д тус нисэх буудлыг 4D ангиллын нисэх буудал болгох, өртгөтгөх зураг, төсөв боловсруулахад 300.0 сая төгрөгийг тусгасан.

Нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байна. /2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. 0%

7/ 2.113.1. Хөшигийн хөндийд тээвэр логистикийн төв байгуулах /Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь 2017-2020/

Биелэлт: Логистикийн төвийн зураглал гаргах ажлаар Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвөөр боловсруулагдах ачааны хэмжээ, логистикийн төвийн хүчин чадал урьдчилсан байдлаар гарна.

Богдхан төмөр замын трасс батлагдсаны дараа Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлнэ.

Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийг Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл, Шинэ нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын ерөнхий төлөвлөгөөний тодотголд тусгуулахаар БХБЯ болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, НЕТГ-т санал хүргүүлэн тусгуулаад байна.

Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 260 дугаар тогтоолоор Концессын зүйлийн жагсаалтын 53² дахь заалт болох “Богдхан төмөр замын төсөл”-ийг хүчингүй болгосон. Азийн хөгжлийн банкнаас Техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад 1 жилийн хугацаатай сунгаж ТЭЗҮ боловсруулах тендер зарлагдсан. Богдхан төмөр замын ТЭЗҮ-д логистикийн төвийн тооцоо судалгаа хамаарагдана.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 265 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын урт хугацааны бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Уг урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн төслийг 2020-2045 онд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад оруулахаар ҮХГ-ын төсөл хариуцсан ажлын хэсэгт хүргүүлээд байна. 40%

8/ 2.113.3 Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа хийх, батлах /Төрөөс логистикийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулах 2017-2018/

Биелэлт: Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах Зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Монголын логистикийн холбоо” ТББ-тай 2017 оны 267 дугаар гэрээг байгуулсан. Тус холбооноос эхлэл, дунд, эцсийн тайлан ирүүлсэн.

Дотоодын ачаа урсгалыг тодорхойлох хаанаас хаашаа ямар бараа бүтээгдэхүүнүүд тээвэрлэгдэж байгаа, гадаад худалдааны бодлого, бусад салбарын баримталж байгаа бодлогоос хамааран ачааны хэмжээнд өөрчлөлт орох эсэхийг тодруулж, ЗТХ-ийн дэд сайдын 2019.05.13-ны өдрийн 02/2431 тоот албан бичгээр холбогдох яамдуудаас санал аваад байна.

Логистикийн төв байгуулах судалгаа хийж, зураглалыг боловсруулсан “Монгол логистикийн холбоо” ТББ-ын ирүүлсэн тайланд санал авахаар ҮХГ-т хүргүүлсэн. ҮХГ-аас бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Засгийн газраар батлуулах нь зүйтэй гэж үзсэн. ЗГ-т танилцуулахаар хамтарч ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 265 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын урт хугацааны бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулан Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 104 дүгээр тушаалаар байгуулагдсан Төрөөс тээвэр, логистикийн талаар баримтлах бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг татан буулгасан. Уг ажлын хэсгийн хүрээнд Зам, тээврийн салбарын урт хугацааны нэгдсэн бодлогыг боловсруулах, тээвэр логистикийн бодлогыг уг бодлогод тусгахаар ажиллаж байна. 40%

9/ 2.114.13 Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах ЗС хүчин чадалтай болгох /ЗС ангиллын агаарын хөлөг хүлээн авах боломжтой болох 2017-2019/

Биелэлт: Сангийн сайд, ЗТХ-ийн сайдын хамтарсан 2018.10.24-ний өдрийн 249/233 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоог батлуулж, Төслийн зохицуулагч, Аэродромын инженер, барилгын инженер, Санхүүгийн ажилтнуудыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллуулж байна. ТХН-ийн ажлын даалгаврыг холбогдох журамд нийцүүлэн боловсруулсан. Төслийн удирдах хороог ЗТХСайдын 2019.06.05-ны өдрийн 177 дугаар тушаалаар байгуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2019.05.02-ны өдрийн 151 дүгээр тушаалаар “Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл”-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулсан. Өндөрхаан нисэх буудлын барилгын ажлын худалдан авалтын тендэрийн баримт бичгийн боловсруулалтыг хийж дууссан. Тендерийг 2019.08.05-ны өдөр зарласан. Нисэх буудлын

байршлыг өөрчлөх саналыг Кувейтийн элчин сайдын яаманд хүргүүлсэн хариу ирэхийг хүлээж байна. 40%

2.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
	100%	70%	40%	0%	Үнэлэх боломжгүй	
2	-	-	-	-	2	-

Үнэлэх боломжгүй арга хэмжээ:

1/ 6.1.1. Ховд аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх барилгын ажлыг эхлүүлэх /Ажлын явц, хувиар 40/

Биелэлт: Ховд нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга, байгууламжийг өргөтгөх зургийн эскизийг ИНЕГ-ын даргаар 2019.03.15-ны өдөр батлуулсан. Зорчигч үйлчилгээний барилгын зураг төсвийг 2019.05.15-ны өдөр хүлээн авахаар “Алтайн газрын хүч” ХХК-тай гэрээг шинэчлэн байгуулсан. Зураг төсөв боловсруулах ажил 70%-тай.

Нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, аэродромыг 4С болгох ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байна. 2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. /үнэлэх боломжгүй/

2/ 6.1.2. Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх барилгын ажлыг эхлүүлэх /Ажлын явц, хувиар 40/

Биелэлт: Өмнөговь аймаг дахь нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэл 80%-тай байна.

Нисэх буудлыг 4D ангиллын, олон улсын нөөц нисэх буудал болгох Зам,тээврийн хөгжлийн сайдын 2 дугаар сарын 01-ний өдрийн 35 дугаар тушаалаар батлуулсан “ИНЕГ-ын 2011, 2013, 2015, 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн зарцуулагдаагүй үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д тус нисэх буудлыг 4D ангиллын нисэх буудал болгох, өртгөтгөх зураг, төсөв боловсруулахад 300.0 сая төгрөгийг тусгасан.

Нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байна. /2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. /үнэлэх боломжгүй/

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
55	28	15	4	-	8	-	84,5%

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ ЗГ-ын тогтоол. Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай 2019.06.28 №259
2. "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрлийг зохих журмын дагуу олгохыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал нарт тус тус үүрэг болгосугай.

Биелэлт: ЗТХЯ-ны зүгээс шаардлагатай зөвшөөрлийг тухай бүрд гаргуулахад анхаарч ажиллана. 30%

2/ ЗГ-ын тогтоол. Монгол-Японы хамтарсан компани байгуулах тухай 2019.06.28 №261
2. "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг эхлүүлэх, шаардлагатай зөвшөөрөл олгоход дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Иргэний нисэхийн ерөнхий газар (Л.Бямбасүрэн), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус үүрэг болгосугай.

Биелэлт: ЗТХЯ-ны зүгээс шаардлагатай зөвшөөрлийг тухай бүрд гаргуулахад анхаарч ажиллана. 30%

3/ ЗГХ-ны тэмдэглэл: 2011.05.25 №26

1.4 Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд тусгагдсан Мандалговь-Даланзадгад чиглэлийн 163 км, Даланзадгад-Оюутолгой чиглэлийн 251 км хатуу хучилттай авто замын ажлын явцыг түргэтгэх, "Гурвансайхан" онгоцны буудлыг өргөтгөх асуудлыг судалж шийдвэрлэх.

Биелэлт: Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 137 дугаар тушаалаар батлагдсан "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт"-д Өмнөговь аймаг дахь нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад 60 сая төгрөг тусгасан. Зураг төслийг хийх тендерт "Алтайн газрын хүч" компани шалгаран 2018.01.18-ны өдөр гэрээ байгуулсан.

2018 оны 09 дүгээр сарын 17-ны байдлаар Гүйцэтгэгч "Алтайн газрын хүч" ХХК нь гэрээний үнийн дүнг нэмэгдүүлэхгүйгээр гэрээт ажлыг үргэлжлүүлэн хийх боломжгүйгээ ИНЕГ-т мэдэгдсэн ба Захиалагчийн талаас гэрээний үнийн дүнд өөрчлөлт оруулах боломжгүйгээ мэдэгдээд байна. Гэрээний талууд урьдчилсан байдлаар үнийн дүнд өөрчлөлт оруулахгүйгээр зураг төслийн ажлыг гүйцэтгэхээр тохиролцсон.

Өмнөговь аймаг дахь нисэх буудлыг 4D ангиллын, олон улсын нөөц нисэх буудал болгох ажлын зураг төсөв боловсруулах 300 сая төгрөгийн санхүүжилтийг ИНЕГ-ын 2019 оны төсөвт тусгасан, зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байна. Урьдчилсан байдлаар 180.0 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай.

Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байна.

2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар зэрэг санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр байна. 30%

4/ ЗГХ-ын тэмдэглэл: 2018.07.09 №30-VI

1. ЗГ-ын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-ын 4 дэх хэсэгт "Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудлын шатахуун хангамжийн менежмент төсөл"-ийг нэмж оруулах асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. Үүнтэй холбогдуулан газрын тос боловсруулах дотоодын үйлдвэр ашиглалтад орсон үес эхлэн онгоцны шинэ буудлын шатахуун хангамжийг дотоодын үйлдвэрээс хангаж байх асуудлыг концессын гэрээнд тусгахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт даалгав.

Биелэлт: Засгийн газрын 2018 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 223 Дугаар тогтоолоор "Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудлын шатахуун хангамжийн менежмент төсөл"-ийг концессийн хөрөнгө оруулах-ашиглах- шилжүүлэх төрлөөр хэлэлцээр хийн, гэрээ байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, гэрээний хэлэлцээрийг хийж, дүнг гэрээний төслийн хамт зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд даалгасан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ЗТХЯ-ны БТГ, АТБХЗХ-ийн мэргэжилтнүүд орж ажиллаж байна. Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах санал Үндэсний хөгжлийн газраас ирүүлсний дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ЗТХЯ-ны БТГ, АТБХЗХ-ийн мэргэжилтнүүдийг оролцуулах саналаа 2019.04.18-ны 04/1902 тоот албан бичгээр хүргүүлсэн. Шатахуун хангамжийн системийг ашиглах боломжийн талаар судлан, Шатахуун хангамжийн байгууламжийн нэгж байгуулан ажиллуулах саналыг Зам, тээврийн хөгжлийн Сайдын зөвлөлийн 2019.06.03-ны хуралдаанаар хэлэлцүүлсэн. Шатахуун хангамжийн үйлчилгээ үзүүлэх нэгжийн төсөв, санхүү, үйл ажиллагааны зардлын талаар судалгааг нарийвчлан хийх шатанд байна. 30%

2.5. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
36	22	11	1	-	-	2	88.2%

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ Төсөл хэрэгжүүлэх тухай 2018.10.24 №249/233

2."Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам"-ын дагуу захиалагчийг төлөөлж ЗТХЯ-ны АТБХЗХ /Д.Мягмарсүрэн/, Сангийн яамыг төлөөлж Хөгжлийн санхүүжилтийн газар /И.Батхүү/-т төслийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тус тус даалгасугай. /Хэнтий аймгийн "Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"/

Биелэлт: 30%

2.6. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
7	5	2	-	-	-	-	91.4%

2.7. Засгийн газрын хуралдаанаар 2019 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс				Хугацаа болоогүй, Хэлэлцүүлэх шаардлагагүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
10	4	1	2	-	3	75,7%

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай/ /2019-04-17/

Биелэлт: Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар Сангийн сайдад хүргүүлэх шатанд байна. 30%

2/ “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2019-09-25/

Биелэлт: Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн Хавсралт 17 “Аюулгүй байдал”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг хянуулах, баталгаажуулах, “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”-т оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг ИНЕГ-ын хэмжээнд бэлтгэх шатанд байна. 30%

3/ Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /2019-03-06/

Биелэлт: Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, төслийг сайжруулан дахин хэлэлцүүлэхээр тогтсон. Сайдын зөвлөлийн гишүүдийн санал, чиглэл болон ХЗДХЯ, Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, саналыг нэгдсэн байдлаар редакцийн чанартай өөрчлөлт хийсэн. Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний дараа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ. 70%

2.8. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс				Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
3	3	-	-	-	-	100,0%

2.9. Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс				Үнэлэх боломжгүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
8	1	3	1	-	3	68.0%

Хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээ:

1/ “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”, “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан, цаашид авах арга хэмжээний талаар 2019.03.29 №09

Биелэлт: 30%

2.10. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс				Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	70%	30%	0%		
7	4	2	-	-	1	90,0%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

Хэлтсийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу ЗГҮАХ, 2018 оны Үндсэн чиглэл, сайд, ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгавраас хэрэгжээгүй арга хэмжээнүүдийг тусган хэлтсийн мэргэжилтнүүдэд нэр заан хариуцуулж, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах ИНЕГ болон бусад нэгж, байгууллагуудын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний хүрэх түвшинг улирал, сараар хуваан төлөвлөсөн байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) АТБХЗХ-ийн 2019 оны III улирлын үйл ажиллагааг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр, 2019 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайд, ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт, СЗХ-наас гарсан шийдвэрийн хэрэгжилт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 10 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 82,1%-тай буюу өмнөх улирлаас 2,6%-иар өссөн дүнтэй байна.
- 2) АТБХЗХ-ийн 2018 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй байна. Үүнд:
 - Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг 2019 оны 2 дугаар сард багтаан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын хаврын чуулганаар батлуулан энэхүү хуультай уялдуулан боловсруулахаар хүлээгдэж буй хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтцийн шинэчлэл хийх ажлуудыг түргэвчлэх;
 - Хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүй төсөл, арга хэмжээнүүд дээр Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна гадаадын зээл, тусламж, концессоор хэрэгжүүлэх боломжийг судлан бусад арга замаар хөрөнгө оруулалт шийдэх, эрчимжүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах, санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;
 - Байнгын ажиллагаатай салбар зөвлөл, хороо, ажлын хэсгүүдийг 1 сард багтаан хуралдуулж, төлөвлөгөөг батлан байнгын ажиллагааг ханган ажиллах, жилийн эцэст төлөвлөгөөт ажлаа дүгнэж хэвших;
- 3) ЗГҮАХ, Үндсэн чиглэлд тусгагдсан боловч санхүүжилт шийдэгдээгүйгээс Хөшигийн хөндийн тээвэр, логистикийн төв байгуулах, Ховд аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох, Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох, Өлгий хотын Нисэх буудлын хатуу хучилттай зурвасыг өргөтгөж, хүнд даацын том онгоц хүлээж авах боломжийг бүрдүүлэх, Өмнөговь аймаг дахь нисэх буудлыг 4D

ангиллын, олон улсын нөөц нисэх буудал болгох ажлууд хэрэгжих боломжгүй болж, тасарсан байна.

- 4) Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах ЗС хүчин чадалтай болгох, “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн барилга”-ыг ашиглалтанд оруулах, Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад оруулахтай холбоотой “Чингис хаан” ОУНБ-ын үйл ажиллагааг шинэ нисэх буудалд шилжүүлэх, шинэ нисэх буудлын үйл ажиллагааг тогтворжуулах “Буянт-Ухаа” нисэх буудлыг цаашид иргэний нисэхийн чиглэлээр ашиглах асуудлыг шийдвэрлүүлэх зэрэг ажлууд удаашралтай хэвээр байна.
- 5) “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 118 арга хэмжээний биелэлт 63,8%-тай буюу хангалтгүй дүнтэй байна. Мөн Агаарын хөлгийн шувуу мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр, Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахгүй, байнгын ажиллагаатай зөвлөл, ажлын хэсгүүдийг хуралдуулахгүй байна.
- 6) “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”, “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-үүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд эдгээр хөтөлбөрүүд нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль батлагдахаас өмнө буюу 2007, 2010 онд боловсруулагдсан тул хуулийн шаардлагуудыг хангахааргүй, бодлого тодорхойлсон хөгжлийн бодлогын баримт бичиг биш, тухайн харилцаанд оролцож буй байгууллагуудын эрх, үүргийг тодорхойлсон, байнга хэрэгжүүлэх, харилцааг зохицуулсан журмын шинжтэй баримт бичиг болсон байна. Сайдын зөвлөлийн хуралдаанаар үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хэлэлцүүлж, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд нийцүүлэн шинэчлэх үүрэг өгсөн боловч хэрэгжихгүй хэвээр байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг 2019 онд ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-ын намрын чуулганаар батлуулан энэхүү хуультай уялдуулан боловсруулахаар хүлээгдэж буй хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бүтцийн шинэчлэл хийх,
2. “Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийн төслийг боловсруулан батлуулах (*орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ, орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ*), Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (*Иргэний агаарын хөлөг, түүний эд анги, бүрэлдэхүүн хэсгийг гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх*) ажлуудыг түргэвчлэх;
3. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх, зөвлөмжийн хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар 11 сард Сайдын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх;
4. Хөрөнгө, санхүүжилт шийдэгдээгүй байгаа нисэх буудлууд /Ховд, Дорнод, Өмнөговь, Өлгий/-ыг өргөтгөх, хүчин чадлыг сайжруулах төсөл, арга хэмжээнүүдийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх талаар Сангийн яаманд төсөвт тусгуулах санал хүргүүлэхээс гадна гадаадын зээл, тусламж, концессоор хэрэгжүүлэх боломжийг судлан бусад арга замаар хөрөнгө оруулалт шийдэх, эрчимжүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах, санал боловсруулж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

5. Хэнтий аймгийн “Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, барилгын ажлыг эхлүүлэх, Ховд, Дорнод, Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх ажлын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах ажлыг 2019 онд багтаан дуусгах;
6. “Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр”, “Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр”-үүдийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль болон Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д нийцүүлэн шинээр боловсруулан батлуулах, эсхүл хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, хугацаа, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцан хэрэгжүүлэх байгууллагыг тодорхой заасан “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулан ЗТХ-ийн сайдаар батлуулах;
7. “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх;
8. Байнгын ажиллагаатай салбар зөвлөл, хороо, ажлын хэсгүүдийг 1 сард багтаан хуралдуулж, төлөвлөгөөг батлан хуралдаанаас гарсан шийдвэрүүдийг хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, байнгын ажиллагааг ханган жилийн эцэст төлөвлөгөөт ажлаа дүгнэж хэвших;

ТАНИЛЦСАН:

САЙД

Б.ЭНХ-АМГАЛАН

ДЭД САЙД

Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

АТБХЗХ-ИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.МЯГМАРСҮРЭН

ХЯНАСАН:

ХШУДАГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ЭНХБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.БАЯРМАА



**ЗТХЯ-НЫ АТБХЗХ-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

/III улирлын байдлаар/

№	Хяналтанд байх арга хэмжээ	2019 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ /Өссөн дүнгээр/	Биелэлт /Хувиар/						Хугацаа болоогүй, хүчингүй болсон, үнэлэх боломжгүй
				Дундаж хувь	100	70	40	30	0	
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	54	44	76,4	22	14	-	6	2	10
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	26	21	78,1	11	6	3	-	1	5
3	Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	2	-	-	-	-	-	-	-	2
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	55	47	84,5	28	15	-	4	-	8
5	Сайдын тушаалын биелэлт	36	34	88,2	22	11	-	1	-	2
6	ТНБД-ын тушаалын биелэлт	7	7	91,4	5	2	-	-	-	-
7	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт	8	5	68,0	1	3	-	1	-	3
8	СЗХ-аар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний биелэлт	3	3	100,0	3	-	-	-	-	-
9	СЗХ-аас гарсан шийдвэрийн биелэлт	8	5	68,0	1	3	-	1	-	3
10	Ил тод, нээлттэй байдлын үнэлгээ	7	6	90,0	4	2	-	-	-	1
Нийт		206	172	82,1	97	56	3	13	3	34



**АГААРЫН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ХЭЛТСИЙН
2019 ОНЫ III УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮНГ ГРАФИКААР ҮЗҮҮЛБЭЛ:**

Дундаж хувь 82,1%

